



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2021 оны 06. сарын 14.-ны
өдрийн 5302 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 17 өдөр

Дугаар A/71

Улаанбаатар хот

Г
Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1.“Багшлах эрх олгох, хасах журам”-ыг, /Багшлах эрх олгох болон сургах зүйн сургалтын хөтөлбөрийн жишиг бүтцийг, багшлах эрхийн үнэмлэхний загвар ,сургах зүйн гэрчилгээний загвар/-ыг хавсралт хэлбэрээр тус тус шинэчлэн баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /А.Халиунаа/, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв /Ц.Батдорж/ нарт тус тус даалгасугай.

САЙД

А.АРИУНЗАЯА



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайдаан 2021 оны 05. сарын
17.ний өдрийн дугаар тушаалын
хаасрагийн

БАГШЛАХ ЭРХ ОЛГОХ, ХАСАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад багшах хүсэлтэй бакалавр түүнээс дээш зэрэгтэй эсвэл мэргэжлийн өндөр зэрэгтэй, үйлдвэрлэлд ажилласан туршлагатай, иргэнд багшах эрх олгох, хасахтай холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журмын зорилго нь мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад багшаар ажиллахад шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшиүүлэх, тасралтгүй хөгжлийг дэмжих, багшийн ёс зүй, нэр хүнд, үүрэг хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

1.3. Багшах эрх олгох, хасах үйл ажиллагаанд хүний эрх, шударга ёс, хууль дээдлэх, ил тод, нээлттэй, тогтвортой, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтална.

Хоёр. Сургалтын хөтөлбөр, агуулга

2.1. Мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагын багшид багшах эрх олгох сургалт нь боловсролын тодорхой түвшинд багшах ур чадварыг эзэмшиүүлэхэд чиглэсэн, шатлан суралцах агуулгын залгамж холбоо бүхий агуулга, хөтөлбөртэй байна.

2.2. Мэргэжлийн сургалтын байгууллагын багшид сургах зүйн гэрчилгээ олгох сургалт нь чадамжид сууринсан сургалтын үндсэн зарчимд нийцсэн байх бөгөөд тухайн салбар, мэргэжлийн онцлогт тохирсон, уян хатан хөтөлбөртэй байна.

2.3. Тухайн сургалтын хөтөлбөрийг танхимиын, танхимиын бус /зайн, цахим/ болон хосолсон хэлбэрээр зохион байгуулж болно.

2.4. Багшах эрх олгох болон сургах зүйн сургалтын хөтөлбөрт тавих ерөнхий шаардлагыг Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

2.5. Журмын 2.1, 2.2-ын дагуу хөтөлбөрийг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл арга зүйн төв боловсруулж,/цаашид МБСҮМАЗТ гэх/ баталгаажуулан, сургалтыг зохион байгуулна.

Гурав. Багшлах эрх олгох

3.1. Багшлах эрх олгох болон сургах зүйн сургалтад хамрагдах иргэн доорх шаардлагыг хангасан байна:

3.1.1.Бакалавр түүнээс дээш боловсролын зэрэгтэй;

3.1.2.Үйлдвэрлэлийн зохих дадлага, туршлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй;

3.2. Сургалтад хамрагдах хүсэлтэй иргэн дараах баримт бичгийг бүрдүүлж, сургалтын байгууллагын удирдлагад хүсэлтээ гаргах ба цахим бүртгэлд бүртгүүлсэн байна. Үүнд:

3.2.1.Өргөдөл;

3.2.2.Анкет;

3.2.3.Журмын 3.1-д заасан шаардлагыг хангасан баримт бичгийн хуулбар;

3.2.4.3x4 хэмжээний 2 ширхэг цээж зураг.

3.3. Шаардлага хангасан багшийн баримт бичгийг сургалтын байгууллагын албан бичгээр баталгаажуулан, МБСУМАЗТ-д 01 ба 09 дүгээр сард багтаан хүргүүлнэ.

3.4. МБСУМАЗТ нь багшлах эрх олгох болон сургах зүйн сургалтыг дууссанаас хойш ажлын 10 хоногт багтаан шаардлага хангасан багш нарын нэрсийн жагсаалт, тайланг Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.5. Багшлах эрх олгох болон сургах зүйн сургалтад хамрагдан сургалтын хөтөлбөрийг бүрэн дүүргэж, тэнцсэн мэргэжлийн болон техникийн боловсролын багшид “БАГШЛАХ ЭРХИЙН ҮНЭМЛЭХ” олгоно.

3.6. Сургах зүйн сургалтын хөтөлбөрийг бүрэн дүүргэж, тэнцсэн мэргэжлийн сургалтын байгууллагын багшид “СУРГАХ ЗҮЙН ГЭРЧИЛГЭЭ” олгоно.

Дөрөв. Багшлах эрх хасах, сэргээх

4.1. Багшийн ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг, үйл ажиллагааны гүйцэтгэлд тавигдах шаардлагыг хангах чадваргүй, багшийн ёс зүйн хэм хэмжээ, нэр төрийг эрхэмлэн сахих үүргээ биелүүлээгүй, сахилгын болон ёс зүйн ноцтой зөрчил гаргасан тохиолдолд багшлах эрхийг хасна.

4.2. Сургалтын байгууллагаас багшлах эрхийг хасуулах тухай саналаа дараах бичиг баримтын хамт бүрдүүлж МБСУМАЗ төвд хүргүүлнэ:

4.2.1. Багшлах эрхийн үнэмлэхний эх хувь;

4.2.2. Багш ёс зүйн дүрмийг зөрчсөн болон багшлах эрх хасах үндэслэлийг нотолсон баримт, тэмдэглэл, гомдол гаргасан этгээдийн өргөдөл;

4.2.3. Сургалтын байгууллагын багш нарын ёс зүйн зөвлөлийн дүгнэлт;

4.2.4. Сургалтын байгууллагын албан бичиг

4.3. Зөрчил гаргасан нь холбогдох дээд байгууллагын дүгнэлтээр батлагдсан бол багшлах эрхийг 1 жилийн хугацаатай хасна.

4.4. Багшлах эрхээ хасуулсан багшийн эрхийг энэхүү журмын 3.1-д заасан шаардлагыг хангасны дараа сэргээж болно.

4.5. Энэ журмын 4.2-д заасан байгууллагын дүгнэлтийг үндэслэн “Багшлах эрх олгох, хасах” тухай шийдвэрийг Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргана.

Тав. Багшлах эрхийн үнэмлэх нөхөн олгох

5.1. Багшлах эрхийн үнэмлэхээ гэмтээсэн, гээж үрэгдүүлсэн тохиолдолд дараах баримт бичгийг үндэслэн нөхөн олгож болно:

- 5.1.1. Багшлах эрхийн үнэмлэх нөхөн авах тухай иргэний хүсэлт;
- 5.1.2. Бичиг баримтын хуулбар;
- 5.1.3. Багшлах эрхийн үнэмлэхийн үндсэн үнийг төлсөн төлбөрийн баримт;
- 5.1.4. 3x4-ийн хэмжээтэй 2 хувь цээж зураг;
- 5.1.5. Сургалтын байгууллагын тодорхойлолт.

5.2. МБСҮМАЗТ нь багшийн мэдээллийн санд үндэслэн багшлах эрхийн үнэмлэх нөхөн олгох үйл ажиллагааг ажлын 21 хоногт багтаан зохион байгуулна.

Зургаа. Багшлах эрхийн үнэмлэхийн загвар

6.1. Багшлах эрх авах шаардлага хангасан мэргэжлийн болон техникийн боловсролын багшид “БАГШЛАХ ЭРХИЙН ҮНЭМЛЭХ” олгоно.

6.2. Мэргэжлийн сургалтын байгууллагад багшлах иргэнд МБСҮМАЗТ-өөс зохион байгуулдаг сургалтад хамрагдаж шаардлага хангасан тохиолдолд “СУРГАХ ЗҮЙН ГЭРЧИЛГЭЭ” олгоно.

6.3. Сургах зүйн гэрчилгээнд судалсан агуулгыг бүрэн оруулсан В5 хэмжээтэй байна.

6.4. Багшлах эрхийн үнэмлэхийн нүүрэн талд “Соёмбо” тэмдэг зурж, “БАГШЛАХ ЭРХИЙН ҮНЭМЛЭХ” гэж Монгол бичиг, крилл үсгээр алтан боронзоор бичнэ.

Долоо. Бусад

7.1. Багшлах эрх олгосон, хассан, нөхөн олгосон багш нарын мэдээллийг бүртгэх, код олгох, мэдээллийн сан үүсгэх, бүртгэлийг шинэчлэх, лавлагаа олгох асуудлыг МБСҮМАЗТ хариуцна.

7.2. Багшлах эрх олгох, хасахтай холбоотой шийдвэрийг эс зөвшөөрвөл тухайн багш холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд шүүхэд хандаж болно.

7.3. Багшлах эрхийн үнэмлэх олгосноос хойш 5 жилийн хугацаанд хүчинтэй байх ба мэдээллийн санд бүртгэлтэй код, дугаартай байна.λ

7.4. Багшлах эрхийн үнэмлэхийн хүчинтэй хугацаа дуусахаас 6 сарын өмнө хүсэлтээ гаргаж холбогдох сургалтад хамрагдан хугацааг 5 жилээр сунгуулна.

7.5. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сунгуулаагүй тохиолдолд багшлах эрхийг тухай бүр хүчингүйд тооцно.

7.6. Багшлах эрхийн үнэмлэхийг хуурамчаар үйлдэн ашиглахыг хориглоно.

7.7. Багшаар ажиллаж байгаад боловсролын салбарын захиргааны болон мэргэжлийн байгууллагад шилжин ажилласан бол багшлах эрх нь үнэмлэхний хүчинтэй хугацаагаар хадгалагдана.

-----000-----

Багшлах эрх олгох, хасах жүймийн
нээдүүсээр хавсралт

“БАГШЛАХ ЭРХ ОЛГОХ БОЛОН СУРГАХ ЗҮЙН” СУРГАЛТЫН ХӨТӨЛБЕРИЙН ЖИШИГ БҮТЭЦ

/Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багшилтгэх хөтөлбэр/

Сургалтын хөтөлбөрийн зорилго:

Сургалтын хугацаа:

Сургалтад багшлах багшид тавигдах шаардлага:

Сургалтад хамрагдах иргэнд тавигдах шаардлага:

Хөтөлбөрийн агуулга:

№	Чадамжийн нэгж	Агуулга	Танхимын цаг		Бие даалтын цаг	Нийт цаг
			Онол	Дадлага		

Арга зүй:

Сургалтын хөтөлбөрийн зорилтод нийцүүлэн олон хувилбарт заах арга зүйн аргачлааар зохион байгуулах

Үнэлгээ:

Сургах зүйн сургалтын хөтөлбөрийн агуулгыг бүрэн судалж, даалгавраа илгээсний дараа тайлан хамгаалалт хийгдэнэ.

Сургалт дууссанаас хойш ажлын 10 хоногт багтаан шаардлага хангасан багш нарын нэрсийн жагсаалт, тайланг Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн терийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Сургах зүйн сургалтын хөтөлбөрийг бүрэн судалж, тэнцсэн мэргэжлийн сургалтын байгууллагын багшид “СУРГАХ ЗҮЙН ГЭРЧИЛГЭЭ” олгоно.

Сургалтаар эзэмших мэдлэг, чадвар:

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багшийн ажил мэргэжлийн лавлах, стандартад үндэслэн эзэмшвэл зохих мэдлэг, ур чадварыг тодорхойлсон байна.



Бие даалтаар хийх даалгавар:

Сургалтын хөтөлбөрийн гол чадамжийн нэгжүүдээр танхимын сургалтыг ажлын байранд бататгах зорилготой ажлын даалгаврыг боловсруулсан байна.

Бие даан унших судлах материал:

Сургалтын хөтөлбөрийн чадамжийн нэг бүрээр бие даан уншиж, судлах ном, сурх бичиг, гарын авлага, холбогдох мэдээллийн эх сурвалжийг оруулна.

Багцлах эрх олгох хасах журмын
хөбөрдүгээр хавсралт



Үзүүлэхийн дугаар: МБС-1	Бүртгэлийн дугаар: МБС-1
Овог:	Сүүлийн 20... оны ...-р сарын ...-ны өдөр хүргэх сүнгэл.
Нэр:	20... оны ...-р сарын ...-ны өдөр
Гарчлан усгэг (төслийн)	
Багцийн багцлах эрх одгох түшиг: Халамжар. Ийнгүйн хамгажлын санамж 20... оны ...-р сарын ...-ны өдөрний дугаар түшигийн үндэслэг Мэргэжлийн болон газарчийн боловсролын сургалтын багцуудындаа багаснаа эрх одгох түшиг.	
Бүртгэлийн дугаар: МБС-1	
Сүүлийн 20... оны ...-р сарын ...-ны өдөр хүргэх сүнгэл.	Сүүлийн 20... оны ...-р сарын ...-ны өдөр
Гарчлан усгэг (төслийн)	
Олгосог: 20... оны ... сарын ... өдөр	

Тайлбар: Үнэмлэхийн дугаарын кодполт
МБ - 21 145 131
МБ - мэргэжлийн боловсрол
21 - тушаал батлагдсан оны сүүлийн 2 орон
145 - тушаалын дугаар
131 - бүртгэлийн дугаар
QR - тухайн багшийн бүртгэлийн мэдээлэл

-----000-----

Баглах эрх олгох, хасах журмын
гуравтугаар хавсралт

СОЮЗНЫЙ
ПАРТИИН ХАМГААНЫ САММЕЛЕНД

СУРГАХ ЗҮЙН ГЭРЧИЛГЭЭ

ЛІГААР. ИС-

ОВОИ _____ ПЛСР _____

Мэргэжлийн боловсруулсан сургалтын бийгүүлигийн багш нийт зориулсан
“СУРГАХ ЗҮЙН” сургалтад хамралдаж шилжүүр хийгдсэн түд гарчихгүй болсон

Мэргэжлийн боловсруулсан сургалтын чиглэгээ мэдээлэлтэй зүйн
төслийн дараа

Улаанбаатар хот 2021 он

СУРГАХ ЗҮЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА:

Cурагсан хугацаа

№	Чадвамжийн нэгжийн код	Эзэмшилж чадвамжийн нэгжийн нэр
1		
2		
3		
4		
5		
6		
7		
8		
9		
10		

/Энэхүү гэрчилгээний багш нь мэргэжлийн боловсруулсан сургалтын бийгүүлэгчийн тусайлыг
мэргэжлийн баглах эрхтай/

Тайлбар: Үнэмлэхийн дугаарын кодлолт

MC - 21 95 18

MC - мэргэжлийн сургалт

21 - тушаал батлагдсан оны сүүлийн 2 орон

95 - тушаалын дугаар

18 - бүртгэлийн дугаар

QR - тухайн багшийн бүртгэлийн мэдээлэл

-----000-----